




Монгол Улсын төрийн албаны шинэчлэлийн үзэл баримтлал

Ц.Даваадулам, НҮБХХ-ийн “Монгол Улсад мэргэшсэн,
иргэн төвтэй төрийн албыг төлөвгшүүлэх нь” төслийн
Техникийн ахлах зөвлөх

2019 оны 2 дугаар сарын 21



Төрийн албаны шинэчлэл



Төрийн албаны тухай хуулийн 1 дүгээр зүйл: Хуулийн зорилго


1.1 “төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх...”

- Соёмбын хоёр хажуугийн босоо тэгш өнцөгт нь эртний бичгийн зүйлд хэрмийг дүрсэлсэн тэмдэг бөгөөд бүх ард түмэн эв санаа нэгтэй болбоос ган хэрмээс ч бат бэх гэсэн ардын цэцэн бэлгэдлийг илэрхийлдэг.
- Монгол Улсын төрийн албаны шинэчлэлийн тулгуур хоёр зорилт нь тогтвортой, мэргэшсэн төрийн албыг бүрдүүлэх явдал мөн.




Төрийн албаны шинэчлэл

Улс төрөөс хараат байдлаас




Улс төрийн хувьд төвийг
сахисан

Улс төрийн нөлөөтэй
томилгооноос




Чадахуйн болон шатлан
дэвшүүлэх зарчимд
үндэслэсэн томилгоо

Бодлого, төлөвлөлтийн
маш олон баримт бичигтэй
боловч хариуцлага
тодорхой бус байдлаас



Тэргүүлэх чиглэлүүд, шат
бүрийн хариуцлага
тодорхой болно.

Төрийн албыг эрх мэдэлд
ойр байх, баталгаатай
ажлын байр гэж хардаг
байдлаас



Иргэнд үйлчлэх сэтгэлгээ,
зан үйлд эерэг өөрчлөлт
орно.

Итгэлцэл



ИТГЭЛЦЭЛ




ИТГЭЛЦЭЛ

Төрийн албан хаагчдын гаргаж буй аливаа шийдвэр, үйлдэл нь **ёс зүйтэй, улс төрийн хувьд төвийг сахисан, шударга**, иргэдэд **хүндэтгэлтэй** ханддаг бол Монголын ард түмэн төрийн албанд итгэж, хүндэтгэлтэй хандана.

- Соёмбын голд байгаа хоёр хэвтээ тэгш өнцөгт нь шулуун шударга, журамтай гэсэн утгатай бөгөөд хүн бүхэн Монгол улсынхаа төлөө цэх шударга нэгэн үзүүрт сэтгэл зүтгэлээр хүчээ өгтүгэй гэсэн санаа юм.
- Шулуун шударга, голч байдал нь итгэлцлийг бий болгодог.



Чадвар



ЧАДВАР



ЧАДВАР

Сонгон шалгаруулах, албан тушаалд томилох, дэвшүүлэх ажиллагаа нь **чадахуйн** болон **шатлан дэвших** зарчимд суурилах тул зөв ур чадвартай, зөв хүнийг зөв албан тушаалд томилж чадна.

- Соёмбын доторх хоёр гурвалжин нь жад, сумны гилбирийг дүрсэлсэн бөгөөд үзүүрийг нь доош хандуулсан нь дайсныг дарах гэсэн утгатай юм.
- Төрийн албан хаагчид ур чадвартай байж гэмээн дотоод, гадаад сорилтуудыг даван туулж чадна.

Үр дүн



Төрийн албан хаагчид юу хийх, үр дүнд хүрсэн эсэх, үр дүнд хүрээгүй бол ямар хариуцлага хүлээхээ мэддэг болох. **Стратегийн удирдлагын хандлага** нь үйл ажиллагаагаа тодорхой төлөвлөх, хувилбаруудын дүн шинжилгээг ул суурьтай хийсний үндсэн дээр чанартай **бодлогын зөвлөгөө** өгөх боломж олгож, байгууллага, хувь хүний түвшинд хүлээх **хариуцлагыг** тодорхой болгоно.

- Соёмбын хамгийн дээр байдаг гурван дөлт гал бол өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагт ямагт бадрах бэлгэдэл юм.
- Монголын ард түмний тусын тулд үр дүнтэй ажилласнаар өсөлт, баялаг, амжилтыг бүтээж чадна.



Иргэн Төвтэй



Төрийн үйлчилгээг төрийн албан хаагчдын итгэл үнэмшил, ашиг сонирхлоос илүү иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хүргэх. Үйлчилгээг төлөвлөхдөө иргэдийг оролцуулах, цогц үйлчилгээг ил тод түншлэлийн замаар хүргэх, бүх хүнийг шаардлагатай мэдээллээр хангах.

- Мөнх тэнгэрийг төлөөлсөн Наран, Саран хоёр бол Монголын ард түмний ашид мандан бадрахын бэлэгдэл болдог.
- Монголын ард түмэн Монгол үндэстний зүрхэнд мөнх орших бөгөөд Монгол Улсын төрийн алба хөх тэнгэрийн доор иргэн төвтэй үйлчилгээг хүргэх эрхэм зорилгоо биелүүлнэ.



“МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН, ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН АЛБЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ” Төсөл



Empowered lives.
Resilient nations.

Хүрэх үр дүн

1. Мэргэжлийн төрийн албыг төлөвшүүлэхэд чиглэсэн эрх зүй, бодлогын хүрээ сайжирна.
2. Төрийн албан хаагчдын мэргэжлийн чадавх сайжирна.
3. Төрийн захиргаан дахь жендэрийн тэгш байдал дээшилнэ.
4. Төрийн захиргааны ажлын гүйцэтгэлд иргэн төвтэй хяналт бий болно.

Хэрэгжих хугацаа

2018-2021

Санхүүжүүлэгч

Канад Улсын Засгийн газар

Нийт төсөв

5.5 сая ам доллар



“МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН, ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН АЛБЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ” Төсөл



Empowered lives.
Resilient nations.

ТҮНШЛЭЛ - Удирдах зөвлөл



Empowered lives.
Resilient nations.



Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх бодлогын өөрчлөлт

- Төрийн албаны шинэтгэл бол сургалтын агуулга, арга барил аль алиныг нь өөрчлөхийг шаардаж байгаа.
- “Сургалт, мэргэшил” бол “боловсрол”-оос ялгаатай.
- **Боловсрол** нь төрийн албан хаагчийг анх ажилд авахад шаардагдах суурь мэдлэгийг олгодог.
- **Сургалт, мэргэшил** нь төрийн албан хаагчийн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, тасралтгүй суралцах соёлыг бий болгоход чиглэдэг.
- Олон улсад сургалтын хэрэгцээ нь иргэдэд өндөр чанартай үйлчилгээ үзүүлэх, бодлого хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдаас шаардагдах зан үйл, ур чадварыг тодорхойлсон **компетенци (мэдлэг, ур чадвар, зан үйлийн нэгдэл)**-тай улам их уялдах болсон.

Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх бодлогын өөрчлөлт

21 дүгээр зуунд шаардлагатай “Шинэ ур чадвар”

- **Оролцогч талуудын олон талт байдлыг зохицуулах** – Улам бүр тодорхой бус, урьдчилан хэлэх боломжгүй болж байгаа оролцогч талуудтай харилцах, үүний дотор нийгмийн сүлжээгээр дамжуулан харилцах.
- **Улс төрийн ороо бусгай байдал, удирдлагын гэнэтийн өөрчлөлтөд дасан зохицох** – Төр засагт итгэх иргэдийн итгэл, төр засгийн легитим байдал буурч байгаа, удирдлага олон удаа, гэнэт өөрчлөгддөг байдлыг даван туулах.
- **Шинэ ажиллах хүчнийг удирдах** – Цоо шинэ үеийн ажиллах хүчний зэрэгцээ ажлын шинэ практиктэй (виртуал, технологижсон, алсын зайны, уян хатан) дасан зохицох
- **Инноваци, шинэ технологи** – Шинэ журам, хөтөлбөр, технологи нэвтрүүлэх, эрсдэлээс сэргийлэх
- **Ёс зүйн хүндрэлтэй байдлуудыг зохицуулах** – Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар шинэ маргаантай асуудлууд, талуудын хараа хяналт ихээхэн нэмэгдэж байгаа байдлыг шийдвэрлэх.
- **Богино ба урт хугацааны асуудлуудыг зохицуулах** – Өнөөдрийн хэрэгцээ, шаардлагыг мэдэрч ажиллахын зэрэгцээ урт хугацааны стратегийн, том дүр зургийг харах
- **Салбар дундын хамтын ажиллагааг зохицуулах.**

Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх бодлогын өөрчлөлт

Уян ур чадвар

- Төрийн байгууллага, хувийн салбар аль аль нь уян ур чадварыг хөгжүүлэхэд улам ихээр анхаарах болсон.
- ТАТХ-ийн 33 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт төрийн жинхэнэ албан тушаалд томилогдох иргэний **удирдан зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, манлайлах, багаар ажиллах** чадварыг шалгахаар заасан.
- Хүнтэй харилцах арга барил, илтгэх урлаг, харилцаа, хамтын ажиллагаа, хэвлэл мэдээлэлтэй харилцах

Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх бодлогын өөрчлөлт

Хүний зан үйлийг удирдах

- Өөрийгөө таних, удирдах
- Стрессийг удирдах
- Шийдвэр гаргах
- Урам зоригийг өдөөх (мотиваци)
- Манлайлал
- Эрх мэдэл, байгууллагын дотоод улс төр
- Багаар ажиллах
- Зөрчлийг зохицуулах
- Өөрчлөлтийн удирдлага

Анхаарал тавьсанд баярлалаа.